



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/61

Шивээговь сум

Бэлгэхийн улаан өндөр овоо тахилгын  
арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар багийн малчдын ирүүлсэн хүсэлтийн дагуу Бэлгэхийн улаан өндөр овоо тахих ёслолын арга хэмжээнд 280,000 (хоёр зуун наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Овоо тахилгад зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд зарцуулагдах 280,000 (хоёр зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлын санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Мөнхцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2022 оны  
05 -р сарын 20 -ны өдрийн 116  
дугаар захирамжийн хавсралт



### АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Бараа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хэвийн боов	25	5.700	142.500
2	Еэвэн	1	21.000	21.000
3	Ааруул	4	25.000	100.000
4	Цагаан самар	1	16.500	16.500
<b>НИЙТ</b>				<b>280,000</b>